

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА



БАТЛАВ  
Ч.МӨНХТУЯА  
2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

## ГАЛЫН ХОРНЫ ДАДЛАГАЖУУРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. ХАБЭА-н гал унтраах дадлага сургалтад жил бүр олон тооны галын хорыг ашигладаг бөгөөд байгаль, цаг уур, орчны (хэт хуурайшил, цас, бороо, цасан болон шороон шуурга) олон шалтгааны улмаас дадлага сургалтыг зохион байгуулахад хүндрэл учирдаг. Тус дадлагажуурыг ашигласнаар галын хорны үргүй зардлыг хэмнэхээс гадна гал унтраах дадлагын үед гарч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

### 2. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Дадлагажуурын иж бүрдэл нь дараах шаардлагыг хангасан эсхүл "Lion Bullex BULLSEYE Digital Simulation Package"-тай дүйцэх.

№	Иж бүрдэл хэсгүүд	Техникийн үзүүлэлт
1.	Зөөврийн дэлгэц бүхий гал унтраагуурын систем	- Лазер гал унтраагууртай хосолж ажиллах - Хэрэглэхэд хялбар программ хангамжтай байх - Ухаалаг утас болон бусад төхөөрөмжтэй холбогдох боломжтой байх
	Зөөврийн дэлгэц	40 инч (багагүй)
	Дэлгэцийн хайрцаг	Дэлгэцийг гэмтээхгүй зөөвөрлөх боломжтой байх
2.	Лазер нунтаг гал унтраагуур	Ердийн ABC нунтаг гал унтраагууртай ижил хэмжээ, бүтэцтэй байх
	Лазер нүүрсхүчлийн хийн гал унтраагуур	Ердийн нүүрсхүчлийн хийн гал унтраагууртай ижил хэмжээ, бүтэцтэй байх
	Гал унтраагуурын цүнх	Дотроо зөөлөвчтэй, бат бөх байх

### 3. БУСАД ШААРДЛАГА:

3.1. Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн дадлагажуурын иж бүрдлийг нийлүүлнэ.

- Техникийн бичиг баримт, ашиглалтын заавар, программ хангамж англи хэл дээр байна.
- Нийлүүлэгч нь дадлагажуурын ашиглалтын зааварчилгааг өгнө.

### 4. ХҮЛЭЭН АВАХ:


4.1 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон иж бүрдлийг шалгаж, бараа хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

4.2. Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 24 сар.

4.3. Барааг хүргэх цэг: "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудал, Нисэхийн сургалтын төв.


**Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:**

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Нисэхийн сургалтын төвийн захирал:



Б. Золбоо

"ХУД яармаг" Төрийн бус байгууллагын гишүүн  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Г. Ганчимэг

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,  
Үнэлгээний хорооны нарийн бичиг



Э. Төмөрхадуур